

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын 5-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/169НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2024 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг:
oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гууламж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 1-6/202

танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН
5 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
М.МӨНГӨНСАРАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын 5-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын 5-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

11001042

Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 27 ширхэг 52 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 10 ширхэг 10.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

Тайлант жилд 50.9 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар тендерийн ялагчгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 94.9 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	99,855,289.99	160,035,604.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	26,279,117.27	86,776,685.32
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	26,279,117.27	86,776,685.32
31210	Төгрөг	26,279,117.27	86,776,685.32
31211	Төрийн сангийн харилцах	16,089,292.27	67,786,860.32
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	10,189,825.00	18,989,825.00
33	АВЛАГА	53,146.80	53,146.80
33500	Бусад авлага	53,146.80	53,146.80
33510	Байгууллагаас авах авлага	53,146.80	53,146.80
35	БАРАА МАТЕРИАЛ	73,523,025.92	73,205,771.92
35100	Түүхий эд материал	10,187,911.92	14,152,711.92
35110	Тусгай зориулалттай материал	10,127,711.92	14,092,511.92
35130	Эм боох материал	60,200.00	60,200.00
35400	Хангамжийн материал	63,335,114.00	59,053,060.00
35410	Бичиг хэргийн материал	932,779.00	1,097,029.00
35420	Аж ахуйн материал	52,745,289.00	52,071,904.00
35440	Түлш, шатах тослох материал	130,000.00	130,000.00
35450	Барилгын засварын материал	100,000.00	100,000.00
35460	Хүнсний материал	7,372,906.00	3,599,987.00
35470	Бусад хангамжийн материал	2,054,140.00	2,054,140.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,098,154,690.20	1,056,803,926.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,098,154,690.20	1,056,803,926.81
39200	Биет хөрөнгө	1,015,141,356.76	973,878,593.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,026,558,576.65	1,026,558,576.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	-76,221,277.59	-102,266,430.99
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	80,700,909.00	80,700,909.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,264,811.57	-51,950,842.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,671,041.36	39,671,041.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,800,176.31	-20,183,737.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,970,093.29	2,970,093.29
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,822,075.07	-2,970,093.29
39217	Ном	1,349,077.00	1,349,077.00
39300	Биет бус хөрөнгө	83,013,333.44	82,925,333.48
39301	Програм хангамж	352,000.00	352,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-234,666.56	-322,666.52
39303	Бусад биет бус хөрөнгө	82,896,000.00	82,896,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,198,009,980.19	1,216,839,530.85
51200	Хуримтлагдсан үр дүн	918,817,722.84	937,647,273.50
51210	Өмнөх үеийн үр дүн	-269,639,285.55	918,817,722.09
51220	Тайлант үеийн үр дүн	1,188,457,008.39	18,829,551.41
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,513,798.85	57,513,798.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,198,009,980.19	1,216,839,530.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,619,558,170.68	538,153,706.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,202,002,419.33	175,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,202,002,419.33	175,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	175,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,135,353,882.61	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	66,648,536.72	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417,555,751.35	537,978,706.83
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	356,102,300.00	493,740,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	356,102,300.00	493,740,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	313,500.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,139,951.35	44,237,806.83
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,139,951.35	44,237,806.83
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	430,921,287.29	519,324,155.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	430,921,287.29	519,324,155.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	425,320,708.40	513,124,155.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,369,510.59	335,208,967.31
210101	Үндсэн цалин	212,044,588.59	252,909,292.87
210102	Нэмэгдэл	44,684,969.00	72,283,005.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	9,639,953.00	10,016,669.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,707,118.14	41,436,663.89
210201	Тэтгэврийн даатгал	22,101,763.49	28,487,387.83
210202	Тэтгэмжийн даатгал	2,651,338.63	3,366,908.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,121,070.54	2,651,866.50
210204	Ажилгүйдлийн даатгал	530,267.73	624,725.93
210205	Эрүүл мэндийн даатгал	5,302,677.75	6,305,775.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,549,107.46	43,870,946.83
210301	Гэрэл, цахилгаан	6,463,643.46	4,701,002.83
210302	Түлш, халаалт	29,846,960.00	34,109,328.00
210303	Цэвэр, бохир ус	6,238,504.00	5,060,616.00
2105	Нормативт зардал	32,703,287.60	40,217,069.00
210502	Хоол, хүнс	32,603,787.60	40,217,069.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	40,000.00
210604	Урсгал засвар	0.00	40,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	804,500.00	1,187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	779,600.00	1,187,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,244,397.41	51,163,508.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,588,180.00	8,461,195.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,000.00	1,351,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,645,217.41	41,350,763.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,600,578.89	6,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,600,000.00	6,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,600,000.00	6,200,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,188,636,883.39	18,829,551.41
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	179,875.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,188,457,008.39	18,829,551.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	435,105,576.35	553,153,706.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,863,325.00	15,175,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,863,325.00	15,175,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,863,325.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,313,500.00	175,000.00
120009	Бусад орлого	0.00	15,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417,242,251.35	537,978,706.83
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	356,102,300.00	493,740,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	356,102,300.00	493,740,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,139,951.35	44,237,806.83
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,139,951.35	44,237,806.83
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	404,200,559.08	492,656,138.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	404,200,559.08	492,656,138.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,599,980.19	486,456,138.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,020,493.88	349,982,221.35
210101	Үндсэн цалин	214,640,281.21	259,828,146.66
210102	Нэмэгдэл	48,295,940.68	80,587,640.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	11,084,271.99	9,566,434.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,959,644.85	41,625,410.60
210201	Тэтгэврийн даатгал	22,665,014.76	28,623,888.27
210202	Тэтгэмжийн даатгал	2,651,338.27	3,419,153.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,121,070.54	2,651,866.50
210204	Ажилгүйдлийн даатгал	530,267.73	624,727.12
210205	Эрүүл мэндийн даатгал	4,991,953.55	6,305,775.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,549,107.46	43,870,946.83
210301	Гэрэл, цахилгаан	6,463,643.46	4,701,002.83
210302	Түлш, халаалт	29,846,960.00	33,869,792.00
210303	Цэвэр, бохир ус	6,238,504.00	5,300,152.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	804,500.00	960,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,358,514.00	13,212,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,308,600.00	11,206,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,049,914.00	2,006,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,600,578.89	6,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,600,000.00	6,200,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (30,905,017.27	60,497,568.05
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,625,900.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,625,900.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,625,900.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,625,900.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-4,625,900.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	26,279,117.27	60,497,568.05
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	26,279,117.27
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,279,117.27	86,776,685.32

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	221,678,458.50	57,513,798.85	-269,639,285.55	9,552,971.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	221,678,458.50	57,513,798.85	-269,639,285.55	9,552,971.80
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,188,457,008.39	1,188,457,008.39
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	221,678,458.50	57,513,798.85	918,817,722.84	1,198,009,980.19
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	221,678,458.50	57,513,798.85	918,817,722.84	1,198,009,980.19
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-0.75	-0.75
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	221,678,458.50	57,513,798.85	918,817,722.09	1,198,009,979.44
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	18,829,551.41	18,829,551.41
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	221,678,458.50	57,513,798.85	937,647,273.50	1,216,839,530.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	509,830,100.00	442,218,331.95	67,611,768.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	509,830,100.00	442,218,331.95	67,611,768.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	509,830,100.00	442,218,331.95	67,611,768.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	392,576,800.00	349,982,221.35	42,594,578.65
210101	Үндсэн цалин	264,170,700.00	259,828,146.66	4,342,553.34
210102	Нэмэгдэл	119,772,500.00	80,587,640.69	39,184,859.31
210104	Урамшуулал	8,633,600.00	9,566,434.00	-932,834.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,071,800.00	41,625,410.60	7,446,389.40
210201	Тэтгэврийн даатгал	33,368,800.00	28,623,888.27	4,744,911.73
210202	Тэтгэмжийн даатгал	3,925,500.00	3,419,153.67	506,346.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,140,900.00	2,651,866.50	489,033.50
210204	Ажилгүйдлийн даатгал	785,400.00	624,727.12	160,672.88
210205	Эрүүл мэндийн даатгал	7,851,200.00	6,305,775.04	1,545,424.96
2105	Нормативт зардал	52,336,200.00	36,438,500.00	15,897,700.00
210502	Хоол, хүнс	52,336,200.00	36,438,500.00	15,897,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	961,200.00	960,200.00	1,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	961,200.00	960,200.00	1,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,884,100.00	13,212,000.00	1,672,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,600.00	11,206,000.00	794,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,883,500.00	2,006,000.00	877,500.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	509,830,100.00	493,915,900.00	15,914,200.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	493,740,900.00	493,740,900.00	0.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	493,740,900.00	493,740,900.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,089,200.00	175,000.00	15,914,200.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	175,000.00	-175,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	16,089,292.27	-16,089,292.27
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	67,786,860.32	-67,786,860.32

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 83,114.7 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 15,000.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

Эхний үлдэгдэл тулган баталгаажуулах үед өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдэл тайлант оны эхний үлдэгдлээс зөрүүтэй байсныг залруулав.

Аудитаар нийт 5 зөрчил илэрсэнд аудитаас зөвлөмж хүргүүлэн ажиллахаар шийдвэрлэлээ. Илрүүлсэн зөрчлийн 59.5 мянган төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчилд хамаарч байгаа нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага байх тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө

5.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд төлбөрийн акт тавигдаагүй болно.

5.2 Албан шаардлага

Тайлант онд албан шаардлага хүргүүлэхгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Санхүүгийн байдлын тайланд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд авлагын дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. Авлагын насжилтын үнэлгээгээ хийж үзэхэд тайлант онд толилуулсан авлага муу авлага гэсэн ангилалд орж байна.

Өгсөн зөвлөмж 1: Авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж эзэн холбогдогчийг тогтоож авлагыг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллах

Илрүүлэлт 2: Үлдэх өртөггүй 49 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд бүртгэлийн хяналт тавьж, үнэ болон ашиглах жилийг шинэчлэн бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6 р сарын 18 өдрийн 271 дүгээр тогтоолын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж 2: Холбогдох хууль, журам заавруудыг мөрдөж ажиллах

Илрүүлэлт 3: Сайншанд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байршуулах ёстой мэдээллийг тулган шалгахад Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 6,068.5 мянган төгрөгийн 4 тушаалыг шилэн дансны цахим системд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 4: А тушаал гарах тухай бүрд шилэн дансанд мэдээлж ажиллах

Илрүүлэлт 4: Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 27 ширхэг 52 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 10 ширхэг 10.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл

хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасны дагуу хяналт тавьж арга хэмжээ аваагүй байна. Мөн тохиолдсон байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 5: И баримтын дүнг тухай бүрд өөрийн байгууллагын бүртгэлтэй тулгаж бодитоор ажил гүйлгээ гараагүй И баримт гарах тухайн харилцагч байгууллагад мэдэгдэж буцаалтыг баталгаажуулж санхүүгийн бүртгэлдээ үнэн зөв баримтыг тусган ажиллах

Илрүүлэлт 5: Тайлант жилд 50,884.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар тендерийн ялагчгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь тус хуулийн 30.4-т заасан шууд гэрээ байгуулах нөхцөлийг бүрэн хангаагүй байна. 30.4.1. тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах; 30.4.2. энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах; 30.4.3. энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах

Өгсөн зөвлөмж 6: 10.0 сая-с дээш үнийн дүн бүхий Бараа материал худалдан авахдаа дээрх хуулиудын дагуу худалдан авалтыг хийж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эхний үлдэгдэл тулган баталгаажуулах үед өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдэл тайлант оны эхний үлдэгдлээс зөрүүтэй байсныг залруулав.	1	15.0			1	15.0	1	15.0				
ДҮН	1	15.0	0	-	1	15.0	1	15.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Харилцаа тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайланд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд авлагын дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. Авлагын насжилтын үнэлгээг хийж үзэхэд тайлант онд тоглуулсан авлага муу авлага гэсэн ангилалд орж байна.	1	53.1					1.00	53.1				
Үлдэх өртөггүй 49 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд бүртгэлийн хяналт тавьж үнэ, болон ашиглах жилийг шинэчлэн бүртгээгүй. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6 р сарын 18 өдрийн 271 дүгээр тогтоолын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.	1	-					1					
ДҮН	2	53.1	-	-	-	-	2	53.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Төо			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай Хөрөнгө зарцуулах тухай 4 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.	1	6,068.5					1	6,068.5
ДҮН	1	6,068.5	0	0	0	0	1	6,068.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Евaгimт- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 27 ширхэг 52 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 10 ширхэг 10.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.	1	10,962.4					1	10,962.4
Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна.	1	50,884.7					1	50,884.7
ДҮН	2	61847.1	0	0	0	0	2	61,847.1

/Мянган төгрөгөөр/